



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/13/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот
2020 он

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: ariunaach@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК

Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ


 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Х.ГАНБОЛД ТАНАА
2020.02.28 № 1-6/194 танай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Х.Ганболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, элэгдэл дууссан ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг дахин үнэлэх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК-ний захирал Ч.Мөнхтуяа, чанарын хяналтын менежер А.Оюун, аудитор Р.Пүрэвсүрэн, туслах аудитор Э.Номинчулуун нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Уваа Уул аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 2 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Чадварлаг багш, чанартай сургалт, бүтээлч суралцагчидтай болох”-д оршино.

Бүрэн дунд боловсролын үйл ажиллагааны чиглэлийг “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 6 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар, гадаад хэлний зохих мэдлэг эзэмшүүлэх;
- Байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;
- Мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх;
- Бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоолоор “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
- Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаал “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-06-10-ны 11/09 “Төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай”
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-12-04-ны 12/07 “Төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна..

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ний “Acoulous, payroll” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 4 дугаар улирлын Санхүүгийн үр дүнгийн тайланг сонгож, эрсдэлийн түвшин “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 604,707.4 мянган төгрөгөөс тооцон 6,047.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6,047.0 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэлийн түвшин “дунд” үзсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,238.4 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0.0	317.6	317.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	61,141.4	82,903.4	21,762.0
Үндсэн хөрөнгө	1,299,073.6	1,293,232.4	-5,841.2
Нийт хөрөнгө	1,360,215.0	1,376,453.4	16,238.4
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,360,215.0	1,376,453.4	16,238.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,360,215.0	1,376,453.4	16,238.4

Авлага дансны үлдэгдэл өссөн нь нэмэлт санхүүжилтийн данснаас татуулсан 317.6 мянган төгрөг байгаагаас шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл өссөн нь түрээсийн ном, сурах бичгийг бүртгэж авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь 10,708.6 мянган төгрөгийн хөрөнгө актaлсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансанд Хөрөнгө оруулалтаар 39,048.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 10,790.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж 10,708.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1 хөтөлбөрт зориулан 641,7245.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 641,724.7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 575,836.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 65,887.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлыг зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 638,438.3 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардлаас 2,337.0 мянга, бусад урсгал шилжүүлгийн зардлаас 866.0 мянган төгрөгийн хэмнэлт гарснаас шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,030.7 мянган төгрөг байна. Үүнээс: хангамж бараа материалын зардалд 255.5 мянган төгрөг, томилолт зочны зардалд 1,413.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 44.1 мянган төгрөг нийт 1,713.1 мянган төгрөгийн зарцуулж үлдэгдэл 317.6 мянган төгрөгийг татуулж авлагаар тусгасан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 горим сорил хэрэгжүүллээ.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 145 мэдээлэл байршуулахаас 143 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Бид Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй, “Оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн бодитой илэрхийлэгдэхгүй байх, хөрөнгийн ашиглалт алдагдах.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, хөрөнгийн ашиглагдах жил, үнийг шинэчлэн тогтоох.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн эрхлэгч, нягтлан бодогч нар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,141,375.64	83,220,966.14
33	АВЛАГА	0.00	317,600.00
33500	Бусад авлага	0.00	317,600.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	317,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	61,141,375.64	82,903,366.14
35100	Түүхий эд материал	3,742,205.48	9,804,205.48
35110	Тусгай зориулалттай материал	3,464,205.48	9,804,205.48
35130	Эм боох материал	278,000.00	0.00
35400	Хангамжийн материал	57,399,170.16	73,099,160.66
35410	Бичиг хэргийн материал	724,200.00	553,200.00
35420	Аж ахуйн материал	41,547,142.20	49,316,337.20
35440	Түлш, шатах тослох материал	2,475,000.00	7,887,000.00
35460	Хүнсний материал	2,219,201.00	1,338,930.00
35470	Бусад хангамжийн материал	10,433,626.96	14,003,693.46
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,299,073,636.26	1,293,232,446.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,299,073,636.26	1,293,232,446.75
39200	Биет хөрөнгө	1,260,937,636.26	1,255,096,446.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,084,895,876.31	1,084,895,876.31
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-13,275,518.81
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	180,790,129.36	205,527,334.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-99,927,642.49	-123,531,800.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,173,300.97	98,942,740.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	-41,515,099.63	-47,627,151.07
39214	Бусад үндсэн хөрөнгө	69,213,350.00	69,213,350.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-40,198,114.22	-42,177,415.02
39217	Ном	18,505,835.96	23,129,030.06
39300	Биет бус хөрөнгө	38,136,000.00	38,136,000.00
39301	Програм хангамж	650,000.00	650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-650,000.00	-650,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	38,136,000.00	38,136,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,360,215,011.90	1,376,453,412.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41300	Өглөг	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,360,215,011.90	1,376,453,412.89
51	Засгийн газрын хувь оролцоо	1,360,215,011.90	1,376,453,412.89
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	571,608,461.20	571,608,461.20
51200	Хуримтлагдсан үр дүн	360,402,515.24	738,661,320.58
51210	Өмнөх үеийн үр дүн	722,438,719.59	722,422,919.59
51220	Тайлант үеийн үр дүн	-362,036,204.35	16,238,400.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	428,204,035.46	66,183,631.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,360,215,011.90	1,376,453,412.89

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	570,231,505.66	660,958,299.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,231,866.66	17,202,899.50
120	Нийтлэг татварын бус орлого	6,231,866.66	17,202,899.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,231,866.66	17,202,899.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,231,866.66	17,202,899.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	563,999,639.00	643,755,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	551,742,500.00	575,836,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	551,742,500.00	575,836,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,257,139.00	2,030,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,910,800.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,346,339.00	2,030,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	65,887,800.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	0.00	65,887,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	572,740,295.08	637,206,999.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	572,740,295.08	637,206,999.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	528,516,161.78	608,644,563.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339,692,843.40	414,007,161.00
210101	Үндсэн цалин	235,728,183.40	346,837,428.00
210102	Нэмэгдэл	54,808,800.00	36,785,000.00
210104	Урамшуулал	28,960,839.00	30,384,733.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,195,021.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,054,321.00	52,633,791.00
210201	Тэтгэврийн даатгал	26,726,751.00	36,298,114.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,341,017.00	4,051,625.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,663,015.00	3,461,480.00
210204	Ажилгүйдлийн даатгал	665,902.00	800,247.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,657,636.00	8,022,325.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,205,738.20	48,735,563.00
210301	Гэрэл, цахилгаан	11,033,715.00	10,980,491.00
210302	Түлш, халаалт	29,193,475.00	35,582,835.00
210303	Цэвэр, бохир ус	978,548.20	2,172,237.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,273,821.20	8,456,253.00
210401	Бичиг хэрэг	2,200,580.00	2,249,850.00
210402	Тээвэр, шатахуун	3,469,085.00	1,396,503.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,845,260.00	1,098,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	1,086,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,578,896.20	2,624,700.00
2105	Нормативт зардал	14,668,275.00	22,311,457.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	486,000.00
210502	Хоол, хүнс	14,668,275.00	21,285,457.00

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	540,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,988,330.00	4,765,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,230,000.00	0.00
210604	Урсгал засвар	2,758,330.00	4,765,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,091,600.00	3,261,000.00
210702	Дотоод албан томилолт	1,091,600.00	3,261,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,864,100.00	869,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,864,100.00	869,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,677,132.98	53,604,838.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,919,739.00	4,002,815.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	659,400.00	1,435,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,097,993.98	48,166,823.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,224,133.30	28,562,436.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,157,300.00	25,276,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	450,000.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,081,600.00	23,676,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,429,500.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	196,200.00	1,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,369.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	25,369.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,041,464.30	3,286,436.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,041,464.30	3,286,436.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-2,508,789.42	23,751,300.16
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	359,527,414.93	7,512,899.17
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,450,874.43	7,512,899.17
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	357,076,540.50	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-362,036,204.35	16,238,400.99

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	565,856,512.40	643,755,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,856,873.40	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,856,873.40	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,856,873.40	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,856,873.40	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	563,999,639.00	643,755,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	551,742,500.00	575,836,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	551,742,500.00	575,836,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,257,139.00	2,030,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,910,800.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,346,339.00	2,030,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	65,887,800.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	0.00	65,887,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	497,676,695.40	604,707,410.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	497,676,695.40	604,707,410.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	452,996,562.10	575,827,374.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	324,935,927.90	414,007,161.00
210101	Үндсэн цалин	219,702,891.90	346,837,428.00
210102	Нэмэгдэл	54,808,800.00	36,785,000.00
210104	Урамшуулал	27,618,236.00	30,384,733.00
210105	Гэрээт ажлын хөлс	22,806,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,054,321.00	52,633,791.00
210201	Тэтгэврийн даатгал	26,946,307.00	36,298,113.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,893,153.00	4,051,625.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,005,463.00	3,461,481.00
210204	Ажилгүйдлийн даатгал	655,291.00	800,246.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,554,107.00	8,022,326.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,680,738.20	51,305,273.00
210301	Гэрэл, цахилгаан	11,033,715.00	10,980,491.00
210302	Түлш, халаалт	31,668,475.00	38,152,545.00
210303	Цэвэр, бохир ус	978,548.20	2,172,237.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,288,665.00	6,240,753.00
210401	Бичиг хэрэг	533,800.00	405,950.00
210402	Тээвэр, шатахуун	2,476,685.00	1,396,503.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,845,260.00	1,098,800.00
210404	Ном, хэвлэл	80,900.00	134,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	1,086,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,102,020.00	2,118,600.00
2105	Нормативт зардал	15,337,620.00	21,900,786.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	208,000.00	208,000.00

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	13,839,620.00	20,405,186.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,290,000.00	1,287,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,962,610.00	21,138,110.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,939,000.00	14,879,910.00
210602	Тавилга	2,822,980.00	189,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	4,200,630.00	6,069,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,091,600.00	3,261,000.00
210702	Дотоод албан томилолт	1,091,600.00	3,261,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,864,100.00	869,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,864,100.00	869,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,780,980.00	4,471,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,581,900.00	394,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,199,080.00	4,077,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,680,133.30	28,880,036.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,613,300.00	25,276,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,054,200.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,129,600.00	23,676,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,429,500.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,369.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	25,369.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	317,600.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	317,600.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,041,464.30	3,286,436.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,041,464.30	3,286,436.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	68,179,817.00	39,047,990.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	68,179,817.00	39,047,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	68,179,817.00	39,047,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	68,179,817.00	39,047,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	68,179,817.00	39,047,990.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-68,179,817.00	-39,047,990.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	533,472,461.20	326,948,681.34	722,322,219.59	1,582,743,362.13
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	116,500.00	116,500.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	533,472,461.20	326,948,681.34	722,438,719.59	1,582,859,862.13
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	101,255,354.12	0.00	101,255,354.12
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	38,136,000.00	0.00	0.00	38,136,000.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-362,036,204.35	-362,036,204.35
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	571,608,461.20	428,204,035.46	360,402,515.24	1,360,215,011.90
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	571,608,461.20	428,204,035.46	360,402,515.24	1,360,215,011.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	571,608,461.20	428,204,035.46	360,402,515.24	1,360,215,011.90
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-362,020,404.35	362,020,404.35	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	16,238,400.99	16,238,400.99
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	571,608,461.20	66,183,631.11	738,661,320.58	1,376,453,412.89

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	641 724 700,00	638 438 264,00	3 286 436,00	99,5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	641 724 700,00	638 438 264,00	3 286 436,00	99,5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	615 582 700,00	613 162 264,00	2 420 436,00	99,6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	414 028 500,00	414 007 161,00	21 339,00	100,0
210101	Үндсэн цалин	346 723 600,00	346 837 428,00	(113 828,00)	100,0
210102	Нэмэгдэл	36 785 000,00	36 785 000,00	-	100,0
210104	Урамшуулал	30 519 900,00	30 384 733,00	135 167,00	99,6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54 970 800,00	52 633 791,00	2 337 009,00	95,7
210201	Тэтгэврийн даатгал	37 516 400,00	36 298 113,00	1 218 287,00	96,8
210202	Тэтгэмжийн даатгал	3 490 900,00	4 051 625,00	(560 725,00)	116,1
210203	ҮОМШӨ-ний даатгал	4 363 700,00	3 461 481,00	902 219,00	79,3
210204	Ажилгүйдлийн даатгал	872 700,00	800 246,00	72 454,00	91,7
210205	Эрүүл мэндийн даатгал	8 727 100,00	8 022 326,00	704 774,00	91,9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51 318 600,00	51 305 273,00	13 327,00	100,0
210301	Гэрэл, цахилгаан	9 643 900,00	10 980 491,00	(1 336 591,00)	113,9
210302	Түлш, халаалт	39 494 000,00	38 152 545,00	1 341 455,00	96,6
210303	Цэвэр, бохир ус	2 180 700,00	2 172 237,00	8 463,00	99,6
2104	Хангамж, бараа материалын зардал	6 500 800,00	6 482 153,00	18 647,00	99,7
210401	Бичиг хэрэг	400 000,00	405 950,00	(5 950,00)	101,5
210402	Тээвэр, шатахуун	1 396 500,00	1 396 503,00	(3,00)	100,0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 109 900,00	1 098 800,00	11 100,00	99,0
210404	Ном, хэвлэл	638 000,00	631 400,00	6 600,00	99,0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1 086 400,00	1 086 400,00	-	100,0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 870 000,00	1 863 100,00	6 900,00	99,6
2105	Нормативт зардал	21 924 800,00	21 900 786,00	24 014,00	99,9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	208 000,00	208 000,00	-	100,0
210502	Хоол, хүнс	20 426 700,00	20 405 186,00	21 514,00	99,9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 290 100,00	1 287 600,00	2 500,00	99,8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59 569 200,00	59 569 200,00	-	100,0
210601	Багаж, техник, хэрэгсэл	29 525 000,00	29 525 000,00	-	100,0
210602	Тавилга	15 475 000,00	15 475 000,00	-	100,0
210604	Урсгал засвар	14 569 200,00	14 569 200,00	-	100,0
2107	Томилолт, зочны зардал	1 850 000,00	1 847 500,00	2 500,00	99,9
210702	Дотоод албан томилолт	1 850 000,00	1 847 500,00	2 500,00	99,9

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	870 000,00	869 000,00	1 000,00	99,9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	870 000,00	869 000,00	1 000,00	99,9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4550000,00	4547400,00	2 600,00	99,9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	350 000,00	350 000,00	-	100,0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4 200 000,00	4 197 400,00	2 600,00	99,9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26142000,00	25276000,00	866 000,00	96,7
2132	Бусад урсгал шилжүүлэг	26 142 000,00	25 276 000,00	866 000,00	96,7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24 542 000,00	23 676 000,00	866 000,00	96,5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1 600 000,00	1 600 000,00	-	100,0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	641 724 700,00	638 438 264,00	3 286 436,00	99,5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	575 836 900,00	572 550 464,00	3 286 436,00	99,4
131001	Улсын төсвөөс санхүүжих	575 836 900,00	572 550 464,00	3 286 436,00	99,4
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	65 887 800,00	65 887 800,00	-	100,0
132001	Орон нутгийн төсвөөс	65 887 800,00	65 887 800,00	-	100,0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00	-	

4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,030,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,030,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,713,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал		255,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		255,100.00
2107	Томилолт, зочны зардал		1,413,500.00
210702	Дотоод албан томилолт		1,413,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		44,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		44,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		317,600.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг		317,600.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		2,030,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,030,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,030,700.00

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.25	Аудитын нэр: Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ТӨА-2020/13/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө байна	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ж.Мөнхсайхан